



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/74

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Нутгийн удирдлагын ордны хуралдааны их танхимын лед дэлгэц нийлүүлэх ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг (Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: З.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Одончимэг (Төрийн бус байгууллагын төлөөлөл)


Ч.Мөнхтөр (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: Х.Дэмид (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Х.Дэмид)-д үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСҮХ



8400003 0412
Tush A/74 Ba